ХӨВСГӨЛ АЙМАГ ЦАГААННУУР СУМЫН ЕБС

ЦАГААННУУР СУМЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч. ОЮУНБАДАМ

ХӨВСГӨЛ АЙМАГ ЦАГААННУУР СУМЫН ЕБС-ИЙН “ТҮЛШ ХАЛААЛТ ХУДАЛДАН АВАХ” ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн дугаар: ХӨАЦНСЗДТГ/20250202037

2025 ОН

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн түлшний мод бэлтгэн нийлүүлэхэд тавигдах техникийн ерөнхий шаардлага

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардалга		Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
1	**Байгаль орчин**	Аймгийн байгаль орчны газрын даргаар батлуулсан ойн менежментийн төлөвлөгөөтэй байх	
		Улсын бүртгэлд бүртгүүлсэн байх	
		Нийт түлээний 20%-ийс ихгүй нь хожуул, гишүү байж болно	
		Осол авааргүй ажиллах. Осол аваар гарсан үед тендер зарласан байгууллага хариуцлага хүлээхгүй	
2	**Машин түлээ бэлтгэх**	Модлог чанар 80%-иас доошгүй байх	
		Нийт модны 90% цэвэрлэгээний огтлолын аргаар бэлтгэсэн байх	
		Нийлүүлж буй мод нь чанар илчлэг сайтай, өмхгүй байх	
		1.95 м-ын урттай байна	
		Түлээ буулгах хугацаа 22 цаг 00 минутаас өмнө буулгаж заавал хүлээлгэж өгнө	
		Түлшийг хэд хэдэн машинаар цувуулан өрж тавиад байгууллагын түлш хүлээн авах комисст хэмжүүлж, шалгуулсаны дараа хөрөөдөж шажилна.	
3	**Түлээ хөрөөдөх**	Хөрөөдөхдөө тайрдасыг 40см-ээс уртгүй бэлтгэнэ	
		Түлшний модыг ормоос илүү гаргахгүй ажиллах	
4	**Шажлахдаа**	Сажийг дөрвөлжлөн нурхааргүй хураана. Хураасны дараа нурж унавал нийлүүлэгч дахин гүйцэтгэж захиалагчийг хохиролгүй болгоно. Нийлүүлэгч нь сажны хураалтад 2-сарын баталгаа гаргаж өгнө.	
		Сажийг 2 талд нь хайрцаглан 3м өндөртэй хураана.	
		Сажийг түлээний суурь хогийг цэвэрлүүлсний дараа хураах бөгөөд хогон дээр хураахыг хориглоно.	

		40см-ийн диаметрээс дээш тайрдасыг 4 хэсэг болгон хагалж өрнө	
5	**Түлээний хогийг цэвэрлэх**	Түлээний хогийг цэвэрлэж ачсаны дараа бэлтгэсэн нийт түлээг ажлын хэсэгт хүлээлгэн өгч гэрээг дуусгавар болгоно.	
6	**Нүүрс**		
6	**Бусад**	Талбай тусгаарлалтын болон түлээний гоожингийн мөнгийг нийлүүлэгч өөрөө хариуцана.	
		Түлш нийлүүлэлтийг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсний дараа байгууллагын түлш хүлээн авах актыг үндэслэн ажлын хөлсийг олгох эрх үүснэ.	
		Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн санхүүжилтийг олгоно. Ажлын гүйцэтгэлээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсийг хувааж олгоно. Эхний ээлжинд ажлын 40%-ийг гүйцэтгэсний дараа түүнд тохирсон санхүүжилтийг олгож эхлэнэ. Ажлын нийт хөлсний 60%-ийг ажлын гүйцэтгэлээр олгох бөгөөд ажил дууссаны дараа ажлын чанар, гүйцэтгэлийг харгалзан үлдэгдэл хөлсийг олгоно. Ажлын гүйцэтгэл дутуу хангалтгүй тохиолдолд ажлын хөлсний 40 хүртлэх хувийг хувилж олгоно.	

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Дугаар	Нийлүүлэх бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт хэмжээ	Нийт үнэ
1	**Түлшны мод**	**$М^3$**	**65.000**	**1167$м^3$**	**75.844.500**